

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

№ ХТ 02/2026

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 12.20 цагаас 12.50 цагийн хооронд Google Meet joining info Video call link: <http://meet.google.com/zbhf-hmrf-guy> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 122,036,314 (нэг зуун хорин хоёр сая гучин зургаан мянга гурван зуун арван дөрөв) ширхэг буюу 69.5 (жаран ес аравны тав) хувийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, компанийн дүрэм болон хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн тул хурал хүчин төгөлдөр болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнх итгэмжлэлээр оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлыг хурлын эхэнд хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хурлыг нээв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Эйс ассошиэйтс ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлэх, бусад банк бус санхүүгийн байгууллагатай нэгдэж байгаа болон нэгтгэж шийдвэр, харилцан гэрээний төслийг батлуулах;
2. Шонхор дронс ХХК нь нэг бүр нь 1(нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) ширхэг буюу 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийн энгийн хувьцаа нэмж гаргах;
3. Шонхор дронс ХХК нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэх.

Тооллогын комиссын дарга Г.Төгөлдөр хуралд ирсэн бүртгэлийн өдрийн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэсэн. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хурлаар хэлэлцэх дээрх асуудлуудыг танилцуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул хэлэлцэж байгаа асуудлаар дэмжсэн, татгалзсан, түдгэлзсэн талаар санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр санал хураагдсан Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Хуралд оролцож буй санал өгсөн саналын хуудсыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг саналтай саналын хуудас гарсангүй. Саналын хуудас дараах байдалтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит бус хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн								Нийт	
		Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Хүчингүй болсон			
		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Эйс ассошиэйтс ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлэх, бусад банк бус санхүүгийн байгууллагатай нэгдэж байгаа болон нэгтгэж шийдвэр, харилцан гэрээний төслийг батлуулах:	122,036,314	100%	-	-	-	-	-	-	122,036,314	100%

2	Шонхор дронс ХХК нь нэг бүр нь 1(нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) ширхэг буюу 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийн энгийн хувьцаа нэмж гаргах;	122,036,314	100%	-	-	-	-	-	-	122,036,314	100%
3	Шонхор дронс ХХК нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэх.	122,036,314	100%	-	-	-	-	-	-	122,036,314	100%
3а	Үүнээс:Саналд сонирхолын зөрчилгүй хувьцаа эзэмшигчийн санал өгсөн хувьцааны ширхэг	10,933,910	100%	-	-	-	-	-	-	10,933,910	100%

“Шонхор дронс ХХК нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэх” саналыг сонирхолын зөрчилтэй хувьцаа эзэмшигчид болох Б.Батхүү, Ц.Хуяг, Ц.Хүдэрмөнх нарын саналыг нийт санал өгсөн хувь эзэмшигчидийн тооноос хасаж 113,883,043 ширхэг хувьцаа болгон тоолсноор бичлэгт хадгалагдсан. Сонирхолын зөрчилтэй “Субашид тек” ХХК-ийн хувьцааг мөн хасах шаардлагатай байсан тул Тооллогын комисс залруулан Тооллогын тогтоолд тусгав.

Хурлын дарга Т.Золбоо Хувьцаа эзэмшигчидэд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй Хурлын шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2026 ОНЫ 07-Р САРЫН 03-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Эйс ассошиэйтс ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлэх, бусад банк бус санхүүгийн байгууллагатай нэгдэж байгаа болон нэгтгэж шийдвэр, харилцан гэрээний төслийг батлуулав;
2. Шонхор дронс ХХК нь нэг бүр нь 1(нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) ширхэг буюу 1,600'000'000 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийн энгийн хувьцаа нэмж гаргав;
3. Шонхор дронс ХХК нэмж гаргасан хувьцааг компанид ноогдох өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэв.

ХУРЛЫН ДАРГА



/Т.ЗОЛБОО/